



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/56

Улаанбаатар хот


Хан-Уул дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөх,
шагнах журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжилж батламж олгох журмыг нэгдүгээр хавсралтаар, “Хүндэт иргэн” тэмдгийн тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар, “Хүндэт иргэн” батламжийн тодорхойлолтыг гуравдугаар хавсралтаар, нэр дэвшигчийн товч танилцуулгын загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Бас-Оргил/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1999 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн “Журам, тодорхойлолт батлах тухай” 39 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



2170100133

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 6 сарын 20
өдрийн А/46 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН “ХҮНДЭТ ИРГЭН”-Д ӨРГӨМЖЛӨХ, ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хан-Уул дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжилж батламж олгох нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон дүүргийн Засаг даргын хамтарсан дээд шагнал мөн.

1.2 Энэ шагналаар Хан-Уул дүүргийн хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, төр, хувийн хэвшлийн салбарт онцгой хувь нэмэр оруулсан, 20-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан Хан-Уул дүүргийн иргэнийг шагнана.

Хоёр. “Хүндэт иргэн”-д олгох шагнал, хүндэтгэл үзүүлэх

2.1 Жил тутам нэг иргэнийг дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжилж, батламж, энгэрийн тэмдэг, мөнгөн шагнал олгоно. Мөнгөн шагналын хэмжээ 500 000 /таван зуун мянга/ төгрөг байна.

2.2 “Хүндэт иргэн”-д хүндэтгэл үзүүлэх зорилгоор дүүрэг байгуулагдсаны ой болон нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас зохион байгуулах арга хэмжээнүүдэд урилгаар оролцуулж байна.

2.3 “Хүндэт иргэн” өргөмжлөлд зориулсан, тэмдэг, батламж хэвлүүлэх, дагалдах мөнгөн урамшуулалд шаардагдах зардлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гаргана.

Гурав. Хан-Уул дүүргийн “Хүндэт иргэн”-д нэр дэвшүүлэх

3.1 Хан-Уул дүүргийн “Хүндэт иргэн”-д
а/ дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
б/ дүүргийн Засаг дарга нэр дэвшүүлнэ.

3.2 Хан-Уул дүүргийн “Хүндэт иргэн”-д өргөмжлөхөөр нэр нь дэвшигдсэн иргэний, ажил, хөдөлмөрийн үр дүн, бүтээлийн талаарх тодорхойлолтыг, холбогдох баримт бичиг /тухайн байгууллагын хүсэлт, хамт олны хурлын тэмдэглэл, нэр дэвшигчийн ажил байдал амжилтын үзүүлэлтийн тухай тодорхойлолт, нэр дэвшигчийн товч танилцуулга/-ийн хамт нэр дэвшүүлэгч этгээдээс тухай бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ирүүлнэ.

Дөрөв. Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, гардуулах

4.1. ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагнуулах тухай тодорхойлолт, дагалдах баримт бичгийг хүлээн авч судлан, тогтоолын төсөл боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд оруулна.

4.2. “Хүндэт иргэн”-д нэр дэвшсэн иргэнийг дүүрэг байгуулагдсаны ой болон Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар жилд нэг удаа хэлэлцэж, шийдвэр гаргана. Хуралд дүүргийн Засаг даргыг урилгаар оролцуулна.

4.3 Шагналыг дүүргийн Төр захиргааны байгууллагын албан байр, танхимд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг дарга хамтран хүндэтгэл үзүүлж, гардуулна.

4.4 Дүүргийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжилж, шагнал гардуулах үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.